



МОНГОЛ УЛС
ДОРНОД АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2018 оны 04 сарын 25 өдөр

Дугаар 21

Чойбалсан

Г Жендерийн эрх тэгш байдлыг хангах 7
дэд хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7 дахь заалт, Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3.4 дэх заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. "Жендерийн эрх тэгш байдлыг хангах дэд хөтөлбөр"-ийг хавсралтаар баталсугай.
2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх санхүүгийн эх үүсвэрийг жил бүрийн аймгийн төсөвт тусган, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн хамтын ажиллагаа, иргэдийн оролцоонд түшиглэн хэрэгжүүлж, үр дүнг тооцож ажиллахыг аймгийн Засаг дарга /М.Бадамсүрэн/-д даалгасугай.



04 004

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2018 оны 04 дүгээр сарын 25-ны
өдрийн 21 дугаартай тогтоолын хавсралт

**ДОРНОД АЙМГИЙН ЖЕНДЭРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДЛЫГ
ХАНГАХ ДЭД ХӨТӨЛБӨР
(2018-2021 он)**

Нэг. Дэд хөтөлбөрийн ерөнхий мэдээлэл

Дорнод аймгийн Жендэрийн эрх тэгш байдлыг хангах дэд хөтөлбөрийг Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Засгийн газрын 2017 оны 129 дүгээр тогтооолоор батлагдсан “Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр” /2017-2021 он/, аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг тус тус үндэслэн боловсрууллаа.

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай Монгол улсын хуулийг хэрэгжүүлэхээр Дорнод аймгийн жендэрийн эрх тэгш байдлыг хангах салбар хороо 2017 оны 01 дүгээр сард 15 хүний бүрэлдэхүүнтэй байгуулагдсан бөгөөд Жендэрт суурилсан мэдлэг ойлголтод тулгуурлан гэр бүлийн амьдралын чанарыг дээшлүүлэх, Хүчирхийлэлд өртсөн болон өртөх эрсдэлтэй охид эмэгтэйчүүдийн хамгааллыг сайжруулах, Өсвөр насны сурагчдын жендэрийн боловсролыг дээшлүүлэх, мэдлэг олгох үйл ажиллагааг явуулсан. Мөн 2015 онд орон нутгийн жендэрийн 10 сургагч багш бэлтгэгдэж ерөнхий боловсролын сургуулийн өсвөр насны нийт хүүхдийн 70 орчим хувьд хүрч ажиллажээ.

Дорнод аймгийн хүн ам 2017 оны жилийн эцсийн байдлаар 79,5 мянга болж өмнөх жилээс 2,2 хувиар өсөж, нийт хүн амын 50.1 хувийг эрэгтэйчүүд, 49.9 хувийг эмэгтэйчүүд эзэлж байна.

Дорнод аймгийн хувьд 2012 онд эрэгтэй хүний дундаж нас 61.87 байсан бол 2016 онд 64.73 болж 2.86 насаар, 2012 онд эмэгтэй хүний дундаж нас 70 нас байсан бол 2016 онд 72.95 болж 2.95 насаар тус тус нэмэгдсэн байна. 2016 оны байдлаар эмэгтэйчүүдийн дундаж наслалт улсын дунджаас 2.15 насаар бага, эрэгтэйчүүдийн дундаж нас 0.85 насаар бага байна.

2017 онд өрх толгойлсон хүний тоо 3969 байгаагаас 71 хувийг /2822/ өрх толгойлсон эмэгтэйчүүд эзэлж байна.

2016 онд Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоо 4137 байсан бол 2017 онд 4394 болж 257 хүнээр нэмэгдсэн байна. Үүний 57,9 хувь нь /2546/ эрэгтэйчүүд байна.

2017 онд 430 хүн нас барсны 59.5 хувийг эрэгтэйчүүд эзэлжбайна. 2017 онд шинээр хорт хавдрын тохиолдол 192 бүртгэгдсэний 56.2 хувь /108/ эрэгтэй, хорт хавдрын өвчинөөр нас баралт 143 тохиолдол бүртгэгдсэний 56.7 хувь /76/ нь эрэгтэйчүүдийн нас баралт эзэлж байна.

2016 онд нийт 419 эмэгтэй үр хөндүүлснээс 95 /22.6%/ тохиолдол нь 15-24 насны залуу охид эмэгтэйчүүдийн үр хөндөлт эзэлж байна.

2017 оны байдлаар гэмт хэрэгт холбогдсон хүний тоо 389 байгаагийн 339 /87.1%/ нь эрэгтэйчүүд, 50 /12.8%/ нь эмэгтэйчүүд эзэлж байна. Гэмт хэрэгт өртөж хохирсон хүүхдийн тоо 37 байгаагаас эмэгтэй 13 /бэлгийн хүчирхийлэл-7/, эрэгтэй-24 байсан бол гэмт хэрэгт холбогдсон хүүхдийн тоо 32, үүнээс 28 нь эрэгтэй, 4 нь эмэгтэй байна. Мөн эрүүжүүлэгдэж saatuuulagdsan хүний тоо 3809 байгаагийн 3543 нь эрэгтэй, 266 нь эмэгтэй байна. Манай аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дэргэдэх гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хохирогчийг хамгаалах байраар 2014-2017 онд нийт 40 хүн үйлчлүүлсэн байна.

2016 онд уул уурхай, олборлолтын ажлын байранд 606 иргэн зуучлагдаж ажлын байраар хангагдснаас 160 /26.4%/ нь эмэгтэйчүүд байсан бол 2017 онд тухайн салбарт 520 иргэн зуучлагдаж ажлын байраар хангагдаж, үүнээс 160 /30.7%/ нь эмэгтэйчүүд эзэлж байна.

2016 онд нийт 76 удаагийн ахуйн гол түймрийн дуудлага бүртгэгдэж 5 иргэн амь насаа алдсаны 4 нь эрэгтэй, 2017 онд 45 удаагийн гол түймрийн дуудлага бүртгэгдэж 1 эрэгтэй гол түймрийн аюулд өртөж нас барсан тохиолдол байна.

2017 оны байдлаар аймаг, сумын ИТХ-ын дарга нарын 6.7 хувь нь, аймгийн ИТХ-ын 35 төлөөлөгчдийн 11.4 хувь нь, сумдын ИТХ-н төлөөлөгчдийн 24.3 хувь нь, аймгийн Засаг даргын Тамгын газрын хэлтэс, албадын даргын 40% нь, төрийн байгууллагын удирдах албан тушаалтны 31.9 хувь нь тус тус эмэгтэйчүүд байна. 2016 оны байдлаар төрийн үйлчилгээний байгууллагад 4774 албан хаагч ажиллаж байгаагийн 66.1 хувь нь эмэгтэйчүүд байна. Ерөнхий боловсролын сургуулиудын захирлуудын 84 хувь, нийт ажиллагчдын 77 хувь нь эмэгтэйчүүд, бага ангийн нийт 277 багшийн 97% эмэгтэй багштай. Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын эрхлэгч, бүлгийн багш нар 100 хувь эмэгтэйчүүд байна. Иймээс төрийн байгууллагын нийт ажилтны дунд аль нэг хүйсийн төлөөлөл илт давамгайлсан тохиолдолд хүйсийн 40:60 гэсэн харьцаа бүхий тэнцвэрт байдлыг хангах нөхцлийг бүрдүүлэх бодлого, арга хэмжээг хэрэгжүүлэх хэрэгцээ шаардлага үүсч байна.

2017 оны 1 дүгээр сарын байдлаар ЕБС-ийн ахлах ангийн 2324 сурагчдын 53.5 хувь нь, MCYT-ийн 336 суралцагчийн 32.1 хувь нь, ПТК-ийн 920 суралцагчийн 32.3 хувь нь, ДИС-ийн 479 суралцагчийн 75.5 хувь нь тус тус эмэгтэй суралцагч, оюутан байгаа нь боловсролын үйлчилгээний түвшин бүрт хүйсийн тэгш харьцаа алдагдсан байна.

Аймгийн хөгжлийн бодлогын 28 баримт бичиг, хөтөлбөрүүдэд нийт 479 зорилт, 2626 үйл ажиллагаа төлөвлөгджээ. Эдгээр орон нутгийн бодлогын баримт бичгүүдэд жендэрийн мэдрэмжтэй бодлого төлөвлөлт болсон эсэхэд үнэлгээ хийсэн мэдээлэл байхгүй байна.

Дээрх тоо баримтуудад дүн шинжилгээ хийж үзэхэд жендэрийн тэгш байдлыг хангах хуулийг хэрэгжүүлэх орон нутгийн чадавхийг бэхжүүлэх, хүн амын хөгжлийг дэмжсэн жендэрийн мэдрэмжтэй бодлого, төлөвлөлт, төсвийг хийх, хэрэгжүүлэх, хянах, иргэд олон нийтийноролцонд тулгуурласан салбар дундын хамтын ажиллагааг сайжруулах, статистик мэдээллийн нэр төрлийг нэмэгдүүлэх, түүнийг ашиглах зэрэг асуудлуудыг шийдвэрлэх хэрэгцээнд тулгуурлаж орон нутгийн онцлогт тохирсон Жендерэрийн эрх тэгш байдлыг хангах дэд хөтөлбөрийг боловсруулав.

Хоёр. Дэд хөтөлбөрийн зорилго, зорилт, хэрэгжүүлэх хугацаа

2.1 Дэд хөтөлбөрийн зорилго:

Бүх нийтэд жендэрийн боловсрол олгох, орон нутагт жендэрийн мэдрэмжтэй бодлого, төлөвлөлтийг нэмэгдүүлэх, жендэрийн эрх тэгш байдлыг хангах орон нутгийн чадавхийг бэхжүүлж, “Жендерэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр” –ийн хэрэгжилтийг хангахад энэхүү дэд хөтөлбөрийн зорилго оршино.

2.2. Дэд хөтөлбөрийн зорилт:

2.2.1 Бүх нийтэд жендэрийн боловсрол олгох сургалт, нөлөөллийн цогц арга хэмжээг хэрэгжүүлэх

2.2.2 Төр, Иргэний нийгмийн байгууллагын түншлэлийн хүрээнд орон нутгийн тогтвортой хөгжлийг дэмжсэн жендэрийн мэдрэмжтэй бодлого, төлөвлөлтийг нэвтрүүлж, хэрэгжүүлэх

2.2.3 Аймаг, орон нутгийн нийгэм, эдийн засгийн хөгжилд жендерийн эрх тэгш оролцоог хангаж, хөгжлийн үр шимээс эрэгтэй, эмэгтэй хүн тэгш хүртэх боломжийг нэмэгдүүлэх

2.3 Дэд хөтөлбөрийн хугацаа:

Дэд хөтөлбөрийг 2018-2021 он хүртэл хэрэгжүүлнэ.

Гурав. Хэрэгжүүлэх үйл ажиллагаа

Зорилт-01:

3.1. Бүх нийтэд жендерийн боловсрол олгох сургалт, нөлөөллийн цогц арга хэмжээг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд:

- 3.1.1 Сургуулийн өмнөх насны хүүхдийн хүчирхийлэлгүй орчинг дэмжих, хүүхэд, ёсвэр нас, оюутан залуус, гэр бүлд жендерт сууринсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх сургалт, нөлөөллийн ажлыг зохион байгуулах;
- 3.1.2 "Аз жаргал төв", гэр бүлд зөвлөгөө өгөх төвүүдийн сургалт, зөвлөн туслах үйлчилгээнд жендер судлал, нөхөн үржихүй, эрүүл мэнд, гэр бүл төлөвлөлт, гэр бүл судлал, охид эмэгтэйчүүдийг хүний наймаа, бэлгийн хүчирхийлэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх сургалт судалгаа, нөлөөллийн үйл ажиллагааг тусгах;
- 3.1.3 Орон нутгийн төрийн удирдах албан тушаалтан, төрийн албан хаагчид болон аж ахуйн нэгж байгууллага, иргэдэд зориулсан жендерийн сургалтуудыг зохион байгуулах, орон нутгийн сургагч багш нарыг чадавхижуулах;
- 3.1.4 Орон нутгийн иргэдийн амьжирага, хүний хөгжлийг тодорхойлдог шалгуур үзүүлэлтүүдийн талаарх төрийн байгууллагууд болон олон нийтийн ойлголтыг нэмэгдүүлж, хэрэглээ болгох ажлуудыг зохион байгуулах;
- 3.1.5 Бүх нийтийн жендерийн мэдлэгийг дээшлүүлэхэд орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран ажиллах;

Зорилт-02:

3.2 Төр, Иргэний нийгмийн байгууллагын түншлэлийн хүрээнд орон нутгийн тогтвортой хөгжлийг дэмжсэн жендерийн мэдрэмжтэй бодлого, төлөвлөлтийг нэвтрүүлж, хэрэгжүүлэх зорилтын хүрээнд:

- 3.2.1 Аймгийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлагууд нь салбар бүртээ, зүүн бүс, аймаг орон нутгийн урт, дунд хугацааны хөгжлийн бодлогод тулгуурлаж, салбарын жендерийн нэгдсэн бодлого, үндэсний болон орон нутгийн дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөтэй болох,
- 3.2.2 Аймаг, сумын хөгжлийн бодлого, байгууллагуудын хөгжлийн төлөвлөгөө, байгууллагын дотоод журам, хүний нөөцийн бодлого, хөтөлбөр, төслийг жендерийн мэдрэмжтэй үзэл баримтлалыг нэвтрүүлэх;
- 3.2.3 Гэр бүлийн хүчирхийлийн хохирогчийг хамгаалах байрны үйл ажиллагааг чанаржуулж, жендерт сууринсан хүчирхийлийн бүх хэлбэрт өртсөн хохирогчдын тоог эрс бууруулах;
- 3.2.4 Аймаг, сумын хэмжээнд ажиллах эрүүл мэнд-сэтгэл зүй-эрх зүйн зөвлөгөөг өгөх бүтэц, гэр бүл судлаач, сэтгэл зүйчийг бэлтгэх, хүний нөөцийг бэлтгэх, гэр бүлийн үнэ цэнэ, хамтын амьдралын утга учир, эцэг эхийн хамтын үүрэг хариуцлагыг таниулах чиглэлээр үр дүнтэй арга хэмжээ зохион байгуулах
- 3.2.5 Орон нутгийн ТББ, Иргэний нийгмийн байгууллагатай хамтран, Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилт, "Жендерийн эрх тэгш

байдлыг хангах үндэсний хөтөлбөр”, аймгийн дэд хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад зөвлөн туслах, сайн туршлагыг түгээх ажлуудыг зохион байгуулах

Зорилт-03:

3.3. Аймаг, орон нутгийн нийгэм, эдийн засгийн хөгжилд жендерийн эрх тэгш оролцоог дэмжиж, хөгжлийн үр шимээс эрэгтэй, эмэгтэй хүн тэгш хүртэхболомжийг нэмэгдүүлэхзорилтын хүрээнд:

- 3.3.1 Үндэсний хөтөлбөрийн хүрээнд улсын хэмжээнд хийгдэх эрэгтэйчүүдийн эрүүл мэнд, боловсрол, залуу малчдын нөхцөл байдал хийгдэх жендерийн судалгаанд тулгуурлаж, эрэгтэйчүүд болон хөвгүүдэд зориулсан кабинетыг байгуулан эрүүл мэндийн үзлэг оношлогоо сэтгэл зүйн зөвлөгөө болон бусад үйлчилгээг нэмэгдүүлэх;
- 3.3.2 Залуу гэр бүл, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, өрх толгойлсон эцэг (эх), амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой иргэн, оюутан залууст чиглэсэн жендерийн мэдрэмжтэй бодлогыг хэрэгжүүлж үр дүнг тодорхойлоход нийгмийн салбарын хөтөлбөрүүдийн уялдаа холбоог хангаж ажиллах;
- 3.3.3 Уул уурхайн салбар болон улирлын шинжтэй ажил, хөдөлмөр эрхэлж буй иргэдийн эрүүл мэнд, ахуй нөхцөл, гэр бүлийн амьжиргаа, тогтвортой байдалд жендерийн дүн шинжилгээ хийж, нөхцөл байдлыг сайжруулах зөвлөмжийг оролцогч талуудад өгөх;
- 3.3.4 Төр, хувийн хэвшлийн ажлын байрыг жендерийн мэдрэмжтэй болгох, эрэгтэй, эмэгтэй ажилтанд адил хэмжээний хөлс олгох, иргэнийг ажилд авахад хүйсээр ялгаварлахгүй байх, ажлын байран дахь хүчирхийллээс сэргийлэх ажлыг Төр, Иргэний нийгмийн байгууллагатай хамтран хэрэгжүүлэх;
- 3.3.5 Хүн амын нийгэм, эдийн засаг, улс төр, соёлын талаар орон нутгийн статистик мэдээллийн нэгдсэн санд хүйсээр ангилсан судалгааны нэр төрөл, тоог нэмэгдүүлж, хөгжлийн бодлого төлөвлөлтөд хэрэглээ болгох;

Дөрөв. Хөтөлбөрийн үр дүн, шалгуур үзүүлэлт

4.1 Хөтөлбөрийг хэрэгжүүлснээр дараах үр дүнд хүрнэ:

- 4.1.1 Аймаг, сумын төрийн болон хувийн хэвшлийн байгууллагын бодлогын баримт бичиг, дотоод журам жендерийн мэдрэмжтэй боловсруулагдсан байна.
- 4.1.2 Жендерийн эрх тэгш байдлыг хангах орон нутгийн чадавхи сайжирч, жендерийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэднийгмийн салбарын хөтөлбөрүүдийн хамтын ажиллагаа хангагдсан байна.
- 4.1.3 Бүх нийтэд жендерийн тухай мэдлэг олгох сургалт, эрүүл дадал хэвшүүлэх үйл ажиллагаа тогтвортой, үр дүнтэй явагддаг болсон байна.
- 4.1.4 Эрэгтэйчүүд судлал, эрэгтэйчүүдэд үзүүлэх цогц үйлчилгээний эхлэл тавигдсан байна.
- 4.1.5 Шийдвэр гаргах болон гүйцэтгэх түвшин дэх хүсийн тэнцвэртэй байдал хангагдсан байна.
- 4.1.6 Жендерт сууринласан хүчирхийллийн хохирогчид үзүүлэх чанартай үйлчилгээ бий болсон байна.

4.2 Хөтөлбөрийн үр дүнг дараах шалгуур үзүүлэлтээр үнэлнэ.

Дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг үнэлэх шалгуур үзүүлэлтийг тогтоохдоо 2017 оны аймгийн жендэрийн статистик тоон мэдээллийг суурь үзүүлэлт болгон авч үзнэ.

№	Шалгуур үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	Суурь түвшин /2017 он/	Хүрэх түвшин	
				2019 он	2021 он
1	Бүх нийтийн жендэрийн ойлголтыг нэмэгдүүлэх модуль сургалт, нөлөөллийн ажил	тоо	3	6	9
2	Жендерийн орон нутгийн сургагч багш	тоо	157	257	307
3	Жендерийн сургалтанд хамрагдсан удирдах ажилтан /УА/, төрийн албан хаагч /ТАХ/	хувь	-	УА-70 ТАХ-150	УА-100 ТАХ-250
4	Орон нутгийн түвшинд хүйсээр ангилсан статистик үзүүлэлтүүд	тоо	15	25	40
5	Хөдөлмөрийн мөлжлөг, ялгаварлан гадуурхалтаас сэргийлэх заалтыг дотоод журамдаа тусгасан байгууллага, аж ахуйн нэгж	хувь	-	20	50
6	Орон нутгийн жендэрийн нөхцөл байдалд ТББ-аас хийсэн судалгаа, тайлан	тоо	1	1	2
7	Жендерийн мэдрэмжтэй, салбарын хүний нөөцийн бодлого төлөвлөлт /оловсрол, соёл урлаг, эрүүл мэнд, аймаг, сумын ЗДТГ/	тоо	-	2	4
8	Эрэгтэйчүүдэд эрүүл мэндийн тусlamж үйлчилгээ үзүүлдэг кабинет	тоо	-	1	1
9	Шийдвэр гаргах түвшинд ажиллаж буй эмэгтэйчүүд	хувь	22,8	-	30,0
10	Хамгаалах байрны үйлчилгээг гэрээлэн гүйцэтгэсэн байгууллага	тоо	-	1	1
11	Дэд хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүнд суурилсан явцын болон эцсийн үнэлгээ, тайлан	тоо	-	1	2

Тав. Санхүүжилтийн үүсвэр

Дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг дараах эх үүсвэрээс санхүүжүүлнэ.

- 5.1 Улсын болон орон нутгийн төсөв
- 5.2 Олон улсын байгууллага, хандивлагч орны тусlamж болон төсөл, хөтөлбөрийн санхүүжилт
- 5.3 Төрийн болон ТББ, аж ахуйн нэгж, иргэдийн хандив тусlamж
- 5.4 Бусад эх үүсвэр

Зургаа. Хөтөлбөрийн удирдлага зохион байгуулалт, хяналт шинжилгээ үнэлгээ

- 6.1 Дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг аймгийн хэмжээнд зохион байгуулахад салбар дундын бодлого, үйл ажиллагааг уялдуулан зохицуулах нэгдсэн удирдлагаар хангах чиг үүргийг Жендерийн эрх тэгш байдлыг хангах аймгийн салбар хороохариуцана.

- 6.2 Дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан батлуулж, хэрэгжүүлэхэд бүх талуудын оролцоог хангах, тэдний санал санаачлагыг дэмжин хамтарч ажиллах, дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг олон нийтэд мэдээлэх, тайланг жил бүр гаргах үүргийг аймгийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар хариуцна.
- 6.3 Дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд оролцогч талууд дараах чиг үүргийг гүйцэтгэнэ:
- 6.3.1 төрийн болон орон нутгийн захиргааны байгууллага нь салбарын, нутаг дэвсгэрийн болон байгууллагын хэмжээнд дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг тухайн жилийнхээ төлөвлөгөөнд тусгах замаар хэрэгжилтийг хангаж зохион байгуулсан ажлын үр дүнг жил бүртайлагнах үүрэг хүлээнэ;
- 6.3.2 Нутгийн өөрөө удирдах байгууллага нь нутаг дэвсгэрийн хэмжээнд хэрэгжүүлэх жендерийн дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж шаардагдах төсвийг батлан төрийн бус байгууллага, хувийн хэвшил, хэвлэл мэдээллийн байгууллага, иргэдийн идэвхи санаачлагыг дэмжин хамтран ажиллана;
- 6.3.3 Төрийн бус байгууллага нь хэрэгжилтийг хангах чиглэлээридэвх, санаачилгатай хамтран ажиллаж, иргэдийн санал, санаачилгыг идэвхжүүлэх, хөтөлбөрийн хэрэгжилтэнд холбогдох журмын дагуу хөндлөнгийн үнэлгээ хийнэ;
- 6.3.4 Аж ахуйн нэгж байгууллага нь нийгмийн хариуцлагын хүрээнд дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд оролцож дэмжлэг үзүүлнэ.
- 6.3.5 Орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллага нь жендерийн эрх тэгш байдлыг хангах, жендерийн ялгаварлан гадуурхалт, хүчирхийллийг үл тэвчих, жендерийн хэвшмэл ойлголт, хандлагыг арилгах чиглэлээр олон нийтийг соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулна.
- 6.4 Жендерийн эрх тэгш байдлыг хангах аймгийн салбар хороо нь хөтөлбөрийн хэрэгжилтэд хийх хяналт-шинжилгээ үнэлгээг дараах хэлбэрээр зохион байгуулна:
- 6.4.1 Дэд хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад хөндлөнгийн үнэлгээний зардлыг 2 жилд нэг удаа аймаг орон нутгийн төсөвт тусгуулан батлуулах;
- 6.4.2 2020 онд дэд хөтөлбөрийн дунд хугацааны зорилtot түвшин болон 2022 онд хөтөлбөрийн зорилtot түвшинд хүрсэн байдалд хөндлөнгийн хяналт шинжилгээ, үнэлгээг хийлгэх.

----оОо----